

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 24 өдөр

№ 01

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Дархан Гурил Тэжээл” Хувьцаат компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.9 заалтыг тус тус удирдлага болгон “Дархан Гурил Тэжээл” ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 04 сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Дархан Гурил Тэжээл” ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1 ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 24 өдөр

№ ...22

Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Дархан Гурил Тэжээл” Хувьцаат компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.1 заалтыг тус тус удирдлага болгон хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 04 сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрэмд дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй.

1.1. Компанийн дүрмийн 2 дугаар зүйл:

“Хоёр. Компанийн салбар, төлөөлөгчийн газар

2.1. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр үйл ажиллагаагаа өргөтгөх, хэрэглэгчид, зах зээлд ойртох зорилгоор дотоодод болон гадаад улсад компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг гүйцэтгэх салбар, мөн компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулах төлөөлөгчийн газрыг байгуулан ажиллуулж болно.

2.2. Компани нь Улаанбаатар хотод төлөөлөгчийн газартай байна.

2.3. Төлөөлөгчийн газар нь гүйцэтгэх удирдлагаас баталсан журмыг баримтлан ажиллана.

2.4. Төлөөлөгчийн газрын удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр томилох бөгөөд компаниас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.”

1.2. Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4.17 дахь заалт:

“6.4.17. Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг шийдвэрлэх.”

1.3. Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4.18 дахь заалт:

“6.4.18. Компанийн салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг томилох, бүтэц, орон тоог батлах.”

2. Компанийн дүрмийн дараах зүйл, заалтыг өөрчлөн найруулсугай.

2.1. Компанийн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.6 дахь хэсэг:

"1.6. Компани нь Монгол улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй байна."

3. Компанийн дүрмийн 2-14 дүгээр зүйл, холбогдох хэсэг, заалтын дугаарыг "3-15" гэж, 6 дугаар зүйлийн 6.4.17 дахь заалтыг "6.4.19" гэж өөрчилсүгэй.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэх, Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал (Б.Түвшинтөр)-д даалгасугай.
5. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 24 өдөр

№ 03

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох, шинээр гишүүн сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугар зүйлийн 62.1.7 дахь заалт, “Дархан Гурил Тэжээл” Хувьцаат компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.7 дахь заалтыг тус тус удирдлага болгон хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 04 сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Дархан Гурил Тэжээл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Сосорбарам овогтой Намсрайжавын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. “Дархан Гурил Тэжээл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сул орон тоонд хувьцаа эзэмшигчдээс олонхийн санал авсан Сумъяа овогтой Энхтайванг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Түвшинтөр)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 24 өдөр

№ 04

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох, шинээр гишүүн сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугар зүйлийн 62.1.7 дахь заалт, “Дархан Гурил Тэжээл” Хувьцаат компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.7 дахь заалтыг тус тус удирдлага болгон хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 04 сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

4. “Дархан Гурил Тэжээл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Самдан овогтой Буянхишигийг бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
5. “Дархан Гурил Тэжээл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сул орон тоонд хувьцаа эзэмшигчдээс олонхийн санал авсан Найдан овогтой Ариунтунгалагийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Түвшинтөр)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 24 өдөр

№ 05

Төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүдийг улируулан сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, 77.2 дахь хэсэг, “Дархан Гурил Тэжээл” Хувьцаат компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсгийг тус тус удирдлага болгон хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 04 сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Дархан Гурил Тэжээл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах ердийн болон хараат бус гишүүдийн бүрэн эрхийг 3 (гурван) жилийн хугацаагаар сунгаж, улируулан сонгосугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн:

- 1) Шаравсамбуу овогтой Энхтөр
- 2) Догсомжав овогтой Балдан-Очир
- 3) Балдан-Очир овогтой Түвшитөр
- 4) Балдан-Очир овогтой Түвшинжаргал
- 5) Баярт овогтой Бадрал

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн:

- 1) Ёндонсүрэн овогтой Амаржаргал
 - 2) Пүрэвдаваа овогтой Мандахнаран
2. Сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР